

**БУГАТ СУМЫН СУУРЬ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН
ДҮНГИЙН ТУХАЙ**

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2017 оны 10 сарын 06-ны өдрийн 1/19 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Бугат сумын Суурь боловсролын сургуулийн 2015, 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч О.Гантуяа 2017 оны 10 сарын 09-ны өдрөөс ажлын 8 хоногт багтаан шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Суурь боловсролын сургуулийн 2015-2016 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, шатахууны хэтрэлт хэмнэлт, зарцуулалт, дотуур байр болон үдийн цай хөтөлбөрийн хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Бугат сумын 3-р багт байрлах Суурь боловсролын сургууль нь суралцагчдад суурь боловсролын стандартыг бүрэн эзэмшүүлэх, суралцах таатай орчин бүрдүүлж, мэдээллийн технологийг сургалтандаа ашигласан, хөгжсөн багш бүхий тэргүүний сургууль болох алсын хараатай. 2015-2016 оны хичээлийн жилд 140 суралцагчид суралцсан.

2015 онд орон тооны бүтэц, цалингийн сангийн тушаал гараагүй ч захирал, сургалтын менежер, багш 12, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, номын санч, нярав, үйлчлэгч 2, тогооч 2, дотуур байрны жижүүр 3, галч 8 нийт 33 орон тоотойгоор, 2016 оны 01 сарын 21-ний өдрийн Б/02 дугаар тушаалын хавсралтаар цалингийн шатлал шинэчлэн тогтоох тухай тушаалаар захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш 11, АББ-ын багш, дотуур байрны багш, номын санч, нярав, сахиул, үйлчлэгч 2, тогооч 2, дотуур байрны жижүүр 3, галч 8 нийт 34 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Тус төвийн санхүүгийн үйл ажиллагааны 1-р гарын үсгийг 2015 оны 01 сарын 01-ээс 2016 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл Х.Тамжид, 2-р гарын үсгийг 2015 оны 01 сарын 01-нээс 2015 оны 12 сарын 04-ний өдрийг хүртэл Б.Дагийсүрэн, 2015 оны 12 сарын 05-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал С.Нямсүрэн нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 040215101 тоот, нэмэлт санхүүжилтийн 040215401 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг санхүүгийн тооцоолох "СТS" программаар бүртгэж хөтөлсөн байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус сургуулийн 2015 оны 12 сарын 31-ний өдрөөрх, 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан нь түүвэрт хамрагдсан тул дүгнэлт гараагүй.

2015 онд Суурь боловсролын сургуулийн 2014-2015 оны дотуур байр болон үдийн цайнд Аймгийн Аудитын газраас шалгалт хийж 141 хүүхэд өдөр илүү бичиж 84.6 мянган төгрөгийн хүнсний материал илүү, хүнсний материалд биет тооллого хийхэд 31.4 мянган төгрөгийн материал дутсанд 2 актаар 116.0 мянган төгрөгийн төлбөр, байрны багшийн хүүхдийн бүртгэл хоолны өдөрлөгтэй зөрсөн 238.4 мянган төгрөгийн төлбөр ноогдуулсныг 2016 оны 06 сарын 30-ны өдөр төлж барагдуулсан байна.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Суурь боловсролын сургуулийн 2015-2016 оны касс харилцах, цалингийн баримт, захирлын тушаал, хүнс, бараа материалын баримт, 2015, 2016 оны санхүүгийн тайлан, дотуур байрны суралцагчдын ирцийн бүртгэл, 2015, 2016 оны хагас, бүтэн жилийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын баримт, хөдөлмөрийн дотоод журам, зэрэг баримт материалуудад тулгуурлан захирал Б.Ариунтунгалаг, сургалтын менежер Л.Соёл-эрдэнэ, нягтлан бодогч Б.Дагийсүрэн, нягтлан бодогчоор ажиллаж байсан С.Нямсүрэн, нярав Х.Галбадрах нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2015 онд төсвөөс 335796.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 330687.0 мянган төгрөгийг авч, үндсэн үйл ажиллагааны орлогыг 5844.3 мянган төгрөгөөр төлөвлөж, 6111.8 мянган төгрөгийг оруулж, нийгмийн даатгалын сангаас тэтгэмжийн 1214.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 53.0 мянган төгрөг бүгд 338066.4 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна. 2016 онд улсын төсвөөс 388009.7 мянган төгрөгийн

санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 388009.7 мянган төгрөгийг авч, туслах үйл ажиллагааны орлогыг 5454.6 мянган төгрөгөөр төлөвлөж, 4405.0 мянган төгрөг оруулж, нийгмийн даатгалын сангаас 6490.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны 3986.0 мянган төгрөг бүгд 402891.2 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

2015 онд төсөвт зардлыг 341640.8 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 336743.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажилчдын цалинд 179969.5 мянган төгрөг, урамшуулалд 58384.1 мянган төгрөг, ндш-д 24758.9 мянган төгрөг, тогтмол зардалд 23150.0 мянган төгрөг, хангамжийн бараа материалд 2593.3 мянган төгрөг, хоол хүнс 16672.8 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 224.8 мянган төгрөг, урсгал засвар 907.0 мянган төгрөг, томилолт 152.4 мянган төгрөг, төлбөр хураамж бусад татварууд 93.8 мянган төгрөг, жижиг эд хогшил 427.4 мянган төгрөг, үдийн цай 6556.2 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага 583.6 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжид 9722.7 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 143.0 мянган төгрөг тус тус зарцуулж, 1 хүний ЖА-ны тэтгэмж 1214.6 мянган төгрөгийг өгч, үлдэгдэл 11189.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

2016 онд төсөвт зардлыг 393464.3 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 400217.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажиллагсадтай холбоотой зардалд 232877.1 мянган төгрөг, ндш-д 26768.7 мянган төгрөг, тогтмол зардалд 30620.1 мянган төгрөг, нормативт зардалд 15346.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 3063.9 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 3158.2 мянган төгрөг, албан томилолтын зардалд 445.0 мянган төгрөг, БҮТЭЗ 9678.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 374.4 мянган төгрөг, хог хаягдал 247.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 469.1 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага 5023.2 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад таван жил тутамд олгох, тэтгэмжид 9570.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжид 4558.5 мянган төгрөг, үдийн цай 9085.9 мянган төгрөг, ЖА-ний тэтгэмж 6490.6 мянган төгрөг, үлдэгдэл 42440.1 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

2015 онд өөрийн үйл ажиллагааны орлого 5844.3 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр түлээ борлуулсны үнэ 6111.8 мянган төгрөгийн орлого орж, төлөвлөгөөг 4.5%-иар биелүүлсэн байна. 2016 онд өөрийн үйл ажиллагааны орлого 5454.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 4405.0 мянган төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 19.2%-иар тасалсан байна..

2016 онд Боловсролын тухай хуулийн 43.1.7 дох заалтыг үндэслэн биеийн тамирийн багш, гадаад хэлний багш, номын санч нарт хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмж нийт 9570.0 мянган төгрөг, мөн байрны жижүүр үйлчлэгч А.Энхтайван, сахиул Б.Одсүрэн нарт тэтгэвэрт гарахад нь олгох тэтгэмж нийт 4558.5 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Нэмэлт санхүүжилтийн 040215401 дугаар дансаар 2015 онд БСГ-аас 53.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирснийг цөм сургалтын бензин шатахууны зардалд

зарцуулсан. 2016 онд БЧШТөсөлөөс 3986.0 мянган төгрөгийн тэтгэлэгт хөтөлбөрөөр Бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний дагуу документ камер 3ш 540.0 мянган төгрөг, зөөврийн спикер 1ш 299.0 мянган төгрөг, Epson проектор 2ш 1655.0 мянган төгрөг, хөлтэй самбар 2ш 120.0 мянган төгрөг, хөгжим 1ш 90.0 мянган төгрөг, боксын бээлий 4ш, малгай 2ш 250.0 мянган төгрөг, монголын товч түүх ном 6ш 120.0 мянган төгрөг, самбар 2ш 90.0 мянган төгрөг, 822.0 мянган төгрөгийн ном худалдан авч үндсэн хөрөнгөнд орлогодсон байна.

Цалин урамшууллын талаар: 2015 онд Сургуулийн захирлын 2015 оны 03 сарын 18-ны өдрийн Б/12 дугаар тушаалаар 29 ажилтанд 15-45%-иар 4664.5 мянган төгрөг, 2015 оны 06 сарын 23-ны өдрийн Б/19 дугаар тушаалаар 32 ажилтанд 15-45%-иар 4224.9 мянган төгрөг, 2015 оны 09 сарын 28-ны өдрийн Б/30 дугаар тушаалаар 31 ажилтанд 5-25%-иар 2040.5 мянган төгрөг, 2015 оны 12 сарын 18-ны өдрийн Б/43 дугаар тушаалаар 18 ажилтанд 15-45%-иар 5281.4 мянган төгрөг, мөн 2015 оны 12 сарын 24-ний өдрийн Б/45 дугаар тушаалаар 32 ажилтанд 50-100%-иар мөнгөн урамшил 8827.8 мянган төгрөгийн тус бүр үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

Сургуулийн захирлын 2015 оны 10 сарын 26-ны өдрийн Б/31 дүгээр тушаалаар номын санч М.Оюунтуяад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал 447.0 мянган төгрөг, 2015 оны 11 сарын 23-ны өдрийн Б/32,33 дугаар тушаалаар сургалтын менежер Л.Соёл-эрдэнэд 25%-ийн ур чадварын нэмэгдэл цалин 157.0 мянган төгрөг, нярав Х.Галбадрахад 25%-ийн ур чадварын нэмэгдэл цалин 104.8 мянган төгрөг, 2015 оны 12 сарын 18-ны өдрийн Б/42 дугаар тушаалаар номын санч М.Оюунтуяад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал 447.0 мянган төгрөг, 2015 оны 12 сарын 24-ний өдрийн Б/46,47 дугаар тушаалаар ур чадварын нэмэгдэл 25%-иар сургалтын менежер Л.Соёл-эрдэнэд 157.0 мянган төгрөг, нярав Х.Галбадрахад 104.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин тус бүр олгосон байна..

Сургуулийн захирал нь 1-р улирлын үр дүнгийн урамшууллыг аймгийн Засаг Даргын 2015 оны 07 сарын 08-ны А/279 дугаар захирамжаар 2015 оны 05 сарын 26-нд 45%-иар 312.2 мянган төгрөг, 2-р улирлын урамшууллыг Аймгийн Засаг Даргын 2015 оны 07 сарын 08-ны А/279 дугаар захирамжаар 45%-иар 312.2 мянган төгрөг, 2015 оны 10 сарын 08-ны А/377 дугаар захирамжаар 45%-иар 312.2 мянган төгрөг нийт 936.6 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон.

2016 онд сургуулийн захирлын 2015 оны 04 сарын 04-ний өдрийн Б/11 дүгээр тушаалаар 33 ажилтанд 15-45%-иар 6297.6 мянган төгрөг, 2016 оны 06 сарын 10-ны өдрийн Б/19 дугаар тушаалаар 32 ажилтанд 15-45%-иар 4127.5 мянган төгрөг, 2016 оны 09 сарын 26-ны өдрийн Б/45 дугаар тушаалаар 28 ажилтанд 10-35%-иар 2230.4 мянган төгрөг, 2015 оны 12 сарын 15-ны өдрийн Б/63 дугаар тушаалаар 27 ажилтанд 31-45%-иар 5098.4 мянган төгрөг нийт 17753.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон.

Сургуулийн захирал нь 1-р улирлын үр дүнгийн урамшуулалт цалинг аймгийн Засаг даргын 2016 оны 04 сарын 06-ны А/142 дугаар захирамжаар 45%-иар 312.2 мянган төгрөг,

2-р улирлын урамшууллыг 2016 оны 06 сарын 30-ны А/307 дугаар захирамжаар 45%-иар 312.2 мянган төгрөг, 2016 оны 10 сарын 17-ны А/451 дүгээр захирамжаар 45%-иар 312.2 мянган төгрөг, 2016 оны 12 сарын 20-ны А/545 дугаар захирамжаар 45%-иар 312.2 мянган төгрөг нийт 1248.8 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон. Аймгийн Засаг даргын 2016 оны 05 сарын 27-ны А/257 дугаар захирамжаар үр чадварын нэмэгдэл 20%-иар 138.7 мянган төгрөг, Сумын Засаг даргын 2016 оны 12 сарын 22-ны А/33 дугаар захирамжаар үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж 100%-иар 693.8 мянган төгрөг тус тус олгосон байна.

2015 оны 01 сард галч Г.Даваа, Ж.Батчулуун нарт үндсэн цалинг 3 сар 20%-иар бууруулахаар, 2015 оны 03 сард Багш Б.Болор-эрдэнэ, Ц.Баатарчулуун, нийгмийн ажилтан Н.Мөнгөншагай нарт үндсэн цалинг 1 сар 20%-иар бууруулахаар сахилгын хариуцлага тооцсон байна.

6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	1471325097			1471325097
2	Авто тээврийн хэрэгсэл	2500000			2500000
3	Машин тоног төхөөрөмж	112831492.76	16111068.05	8484277	120458283.81
4	Тавилга, эд хогшил	67082978.50	522000	9085415.90	58519562.60
5	Номын фонд	9917058.16	405882	3536807.18	6786132.98
6	Бусад үндсэн хөрөнгө	3126314			3126314
7	Биет бус хөрөнгө	250000			250000
	Дүн	1667032940.42	17038950.05	21106500.08	1662965390.39

2015 оны эхэнд 1667032.9 сая төгрөгийн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 405.9 мянган төгрөгийн ном худалдан авч, Хандив тусламжаар 350.0 мянган төгрөгийн насос мотор, 522.0 мянган төгрөгийн сагсны шийд турник, 15761.0 мянган төгрөгийн 14 ш зөөврийн компьютерийг орлогод авч, 8484.2 мянган төгрөгийн 16 нэр төрлийн 5ш компьютер, зөөврийн компьютер, 2ш телевизор, принтер будаа агшаагч, цахилгаан хөрөө, насос, мотор зэрэг тоног төхөөрөмж, 9085.4 мянган төгрөгийн 30 нэр төрлийн 514 ш төмөр хөлтэй ширээ, багш ширээ, багш сандал түлээний хөрөө, сандал, диван ор, тоолуур, оёдлын машин, шкаф, 1, 2 хоолны таваг, коструль, дотуур байрны сандал зэрэг эд хогшил, 267 нэр төрлийн 2115 ш 3536.8 мянган төгрөгийн ном нийт 21106.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг байгууллагын даргын тушаалаар акталсан.

мянган төгрөгийн ном нийт 21106.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж нийт 1662965.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	1471325097	0		1471325097
2	Авто тээврийн хэрэгсэл	2500000	0		2500000
3	Машин тоног төхөөрөмж	120458283.81	16219805.83	4900000	131778089.64
4	Тавилга, эд хогшил	58519562.60	2373959.06		60893521.66
5	Номын фонд	6786132.98	1633863.04		8419996.02
6	Бусад үндсэн хөрөнгө	3126314	15546091.60		18672405.60
7	Биет бус хөрөнгө	250000			250000
	Дүн	1662965390.39	35773719.53	4900000	1693839109.92

2016 оны эхэнд 1662965.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 1495.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 1007.0 мянган төгрөгийн эд хогшил худалдан авч, иргэдээс 32 инч телевизор 1ш, усны насос, 42 инч телевизор 2ш, ДЗОУБ-аас хөл бөмбөгийн зүлэг, төмөр хаалга, сагсны шийд, МТЧДҮТөвөөс камер, проектор, дэлгэц, хөлтэй самбар, 37 нэр төрлийн 53ш ном, БЧШТөсөлөөс 31 нэр төрлийн 92ш ном, зэрэг 32961.1 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар авч орлогодон, 4900.0 мянган төгрөгийн 1-р хоолны тогоог балансаас балансад хялганатын сургуульд шилжүүлж оны эцэст 1693839.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Хүнсний материал	498319.25	15709750	13583821.79	2624247.46
2	Бичиг хэрэг	934824			934824
3	Аж ахуйн материал	36103440.53	2744100	6246307	32601233.53
4	Эм боох материал	112000	40000	152000	
5	Сэлбэг хэрэгсэл	884118.10	7494290	7311460.10	1066948
6	Түлш шатах тослох	6658000	16323170	15897170	7084000
	НИЙТ ДҮН	45190701.88	42311310	43190758.89	44311252.99

Аж ахуйн материалд 175.0 мянган төгрөгийн бөмбөг, волейболын тор төгсөгчдийн хандиваар орлого авч, 128 нэр төрлийн 531 ш 4545.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, сэлбэг хэрэгслээс 17.5 мянган төгрөгийн материал, хүнсний материалаас 13.9 мянган төгрөгийн материал нийт 4577.0 мянган төгрөгийн бараа материал ахталсан байна.

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Хүнсний материал	2624247.46	12670340	13285080.06	2009507.40
2	Бичиг хэрэг	934824		934824	

3	Аж ахуйн материал	32601233.53	22324943.27	4171650	50754526.80
4	Эм боох материал		115800	90000	25800
5	Сэлбэг хэрэгсэл	1066948	9194110	8189306.75	2071751.25
6	Түлш шатах тослох	7084000	5644460	12633460	95000
	НИЙТ ДҮН	44311252.99	49949653.27	39304320.81	54956585.45

Аж ахуйн материалд ДЗОУБ-аас модем, панасоник, хард диск 367.7 мянган төгрөгийн хандиваар орлого авч, 934.8 мянган төгрөгийн номыг үндсэн хөрөнгийн ном дансанд шилжүүлсэн байна.

6.4. Өглөг, авлагын талаар: 2015 оны эцэст гэрэл цахилгааны өглөгт 559.4 мянган төгрөг, хоол хүнс 15.0 мянган төгрөг нийт 574.4 мянган төгрөгийн өглөгтэй байсныг барагдуулсан ч, 2016 онд өглөгийн хувьд оны эцэст 171.4 мянган төгрөгийн цалингийн өглөгтэй, 52.9 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагатай тайлан баланс гарсан байна.

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2017 онд нийт 109 мэдээлэл оруулахаас 114 мэдээллийг хугацаанд нь 4 мэдээллийг хугацаа хоцроосон, 1 мэдээлэл огт тавиагүй байна. Дараа жилийн төсвийн төслийг тавиагүй байна.

ДОЛОО. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд гаргаж, зөрчилгүй тушаасан, няравын баримтыг эмх цэгцтэй үдэж архивласан.

НАЙМ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. 2015 оны 12 сарын 20-ноос хойших харилцахын 29 ш баримтанд, 2016 оны 11 сарын харилцахын 21ш баримт, 2016 оны 02 сарын харилцахын 23 ш баримтанд төрийн сангийн гүйлгээний тэмдэг, гарын үсэггүй, баталгаажаагүй гүйлгээ хийгдсэн нь 2012 оны Засгийн газрын 205 дугаар тогтоол “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.5-д /Төсвийн байгууллага төлбөрийн хүсэлт ТТ-1 маягт, ТТ-2 маягтын 2 хувь ямар нэгэн засваргүй бичиж, ирэх бөгөөд Төрийн сан нь төлбөрийг гүйцэтгэхдээ анхан шатны болон үндэслэх баримтуудыг хяналтын хуудастай тулган хянаж, Төрийн сангийн тэмдэг дарж баталгаажуулан төсвийн байгууллагад өгнө/. гэснийг зөрчсөн.

2. 2015 оны 1 дүгээр сараас 6 дугаар сар хүртэл 3-р багийн иргэн Н.Лхагвасүрэнгийн нарийн боовны цехээс үдийн цай хөтөлбөрт боов цай нийлүүлж, 740.4 мянган төгрөгийн зардал гарсныг материалын тайланд тусгалгүй шууд зардалд бичсэн нь Сангийн сайдын 2016 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагад мөрдөх НББ-ийн дансны заавар”-ын 4.21 дэх заалтыг зөрчсөн.

3. Сургуулийн дотоод журмын 6.1.1-д хүчингүй болсон төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн заалт оруулсан ба тамга тэмдэгээр баталгаажуулагүй байна.

4. 2015 оны Багш ажилчдын 1-4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалт цалингийн тушаал шийдвэрүүдийг 2013 онд хүчингүй болсон Засгийн газрын 54 дүгээр тогтоолыг үндэслэн гаргасан байна.

5. Нярав үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг тайлан гаргадаггүй, нэмэгдсэн хөрөнгийг “Үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх” анхан шатны баримтаар хүлээн авдаггүй, нягтлан санхүүгийн программдаа үндсэн хөрөнгийг шууд шивдэг, хагас бүтэн жилээр тооллогын комисс үндсэн хөрөнгийн тооллого хийж баримтжуулсан.

6. Үдийн цай, дотуур байрны хүнс, шатахуун, түлээний тайлангаас бусад бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, нормын хувцас зөөлөн эдлэл, урсгал засварын материалын тайлангуудыг тусад нь гаргадаггүй, зөвхөн аж ахуйн материалын тайлангаар нэг гардаг.

7. Захирлын 2016 оны 03 дугаар сарын 15-ны Б/05 дугаар тушаалаар сургалтын менежер Л.Соёл-эрдэнэд ур чадварын нэмэгдэл 25%-ийг 03 сараас эхлэн ямар хугацаатай олгох нь тодорхойгүй тушаал гарч сар бүр 160.2 мянган төгрөгийг 12 сарыг дуустал нийт 1189.1 мянган төгрөгийг олгосон нь Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 63/104 дугаар тушаалын байна.

8. Бугат сумын Арилжааны банкн дахь төрийн сангийн түр 5273001245 тоот дансаар 2015 онд 1320.9 мянган төгрөг, 2016 онд 691.4 мянган төгрөг нийт 2012.3 мянган төгрөгийг бэлнээр гаргаж зарцуулсан.

9. 2016 онд шуудан холбооны зардлаас захирал, сургалтын менежер, номын санч, нярав нарын гар утасны зардалд нийт 290.0 мянган төгрөг зарцуулсан нь 2016 оны УИХ-ын 47 дугаар тогтоолын 2-д /Албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй/ гэсэн заалтыг зөрчсөн.

10. ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн 040255401 тоот данснаас Мод тарьсны шагнал 225.0 мянган төгрөгийг сургуулийн нярав Х.Галбадрах нь бэлнээр хүлээн авсан ч бэлэн мөнгөний тайланд тусгаагүй, багш ажилчдын зугаалганы хүнсэнд зарцуулснаар тайлан гаргасан байна.

ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 4 актаар 2847.2 мянган төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлэх, 16.0 мянган төгрөгийн томилолтыг багш нарт нөхөн олгуулахаар акт тогтоолоо. Шалгалтын хугацаанд 7 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

АРАВ. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1, 7.5, 7.7 дахь, /хуучнаар/ 13.1, 13.5, 13.7 дахь /шинэчилсэн/, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтуудын хэрэгжилт хангалтгүй, мөн шалгалтаар илэрч байгаа нийтлэг зөрчлүүд нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт сул байна дүгнэлээ.

АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай, төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Бэлэн мөнгө татаж зарцуулахыг таслан зогсоож Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлж ажиллах

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ О.ГАНТУЯА